

ТАВААРЫН
ЗАХ ЗЭЭЛИЙН
ДОЛОО
ХОНОГИЙН
ТОЙМ

Алт
Газрын тос

2022 оны 8-р сарын 15

Холбооны Нөөцийн Сангийн (ХНС) авч хэрэгжүүлж байгаа мөнгөний хатуу бодлогын хүрээнд хэрэглээний үнийн индекс буурч гарсан нь ам.долларыг сулруулж, алтын ханшийг өсөхөд голлох нөлөө үзүүлээ.

ХНС-гийн зарим ажилчид бодлогын хүүг дахин хүчтэй нэмэгдүүлж инфляцийг хяналтандаа авах нь зүйтэй хэмээн үзэж байгаа бол зарим хэсэг нь бодлогын хүүг нөхцөл байдалдаа тохируулан өсгөх шаардлагатай хэмээн үзэж байна. Одоогоор байдлаар дараагийн хурлаар ХНС бодлогын хүүг 0.5 суурь нэгжээр нэмэх магадлал хамгийн өндөр байна.

Дэлхийн хамгийн том алтаар баталгаажсан биржийн арилжааны сан болох SPDR Gold Trust-ийн мэдээлснээр, өнгөрсөн баасан гарагт өөрийн эзэмшлийн алтны хэмжээ нь 0.15%-иар буурч 995.97 тонн болжээ.



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжлэх болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бүсэд түгээн олшруулахыг хатву хориглоно.



ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

2022 оны 8-р сарын 15

Даваа гарагийг газрын тос уналтаар эхлүүлж байна.

Шалтгаан:

- АНУ-ын жолоодлогын улирал дуусч, шатахууны эрэлт буурч байна
- Дэлхийн том газрын тос олборлогч Арамко компани шаардлагатай бол гарцаа нэмэгдүүлэхэд бэлэн хэмээн мэдэгдсэн
- АНУ-ын Мексикийн булангийн газрын тос олборлох платформууд өнгөрсөн долоо хоногт богино хугацаанд тасалдсаны дараа дахин ажиллаж эхэлсэн

Брент маркийн нефтийн фьючерс 27 цент буюу 0.3%-иар буурч, баррель нь 97.88 ам.долларт хүрсэн. АНУ-ын баруун Техасын газрын тосны үнэ 0.2%-иар буурч 91.87 ам.доллар болжээ.

Саудын Арамкогийн Гүйцэтгэх захирал Амин Нассер ням гарагт сэтгүүлчдэд хэлэхдээ Саудын Арабын засгийн газар хүсэлт гаргавал Saudi Aramco түүхий нефтийн олборлолтоо өдөрт 12 сая баррельд хүргэхэд бэлэн байна хэмээжээ.

Засгийн газар, эрчим хүчний яамнаас олборлолтоо нэмэгдүүлэх шаардлага гарсан үед, эсвэл эрчим хүчний яамнаас уриалга гарвал бид өдөрт 12 сая баррель үйлдвэрлэж чадна гэдэгтээ итгэлтэй байна. Мөн Хятад улс COVID-19-ийн хязгаарлалтыг хөнгөвчлөх, агаарын тээврийн салбарыг сэргээх нь эрэлтийг нэмэгдүүлж магадгүй юм.

Мексикийн булангийн хэд хэдэн офшор платформ дээр газрын тосны хоолойн эвдрэл гэмтсэний улмаас газрын тосны үнэ өнгөрсөн долоо хоногт гурван хувиар өсөв. Баасан гарагийн орой засварын ажил дууссаны дараа үйлдвэрлэгчид зогссон үйлдвэрлэлээ дахин идэвхжүүлэхээр шилжсэн гэж Луизиана мужийн албаны ажилтан мэдэгдэв.



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.